| | боловсруулах ажлыг зохион байгуулж хяналт тавих | хүргүүлсэн байдал, хэрэгжилтийн хувь | төсвийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хуулийн хугацаанд хүргүүлж батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан. | оруулах санал, хуулийн хугацаанд хүргүүлж, батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна. | шимтгэл, тогтмол хэрэглээний зардлууд (цахилгаан, дулаан, ус, холбоо, шатахуун), урсгал засвар, лаборатори, ажиглалтын багаж тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахтай холбоотой зардлыг бодит хэрэгцээнд үндэслэн тусгасан болно.<br>2. Мөн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны эрсдэлийн мэдээллийг орон даяар тасралтгүй цуглуулах, боловсруулж хүргэхтэй холбоотой хээрийн ажиглалт, тээвэр, мэдээ дамжуулалт, мэдээллийн сангийн үйл ажиллагааг хангах зардлуудыг төсөвт оновчтой тооцон тусгасан.<br>3. Хөрөнгө оруулалтын төслийг барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, зураг төсөв гэсэн ангиллаар боловсруулсан. 2025 онд урсгал зардал, төсвийн хүрэлцээ нэмэгдсэнтэй холбоотой дутагдалтай байгаа тооцон судалгаа авч, байгууллага бүрээр тооцоо, судалгааг гарган, төсвийн тодотгол хийх санал боловсруулж байна.<br>4. Боловсруулсан урсгал зардлын төсвийн төслийг холбогдох хугацаанд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлэн, баталгаажуулах, хамгаалах шат дараалалтайгаар ажиллаж байна. | | |
| 43 | Арга хэмжээ 6.5. Ус цаг уур, орчны шинжилгээний салбараас Монгол улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарт оруулах | Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт оруулах саналыг хуулийн хугацаанд хүргүүлсэн байдал /Саналын тоо/ | 26 байгууллагын 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт оруулах саналыг хуулийн хугацаанд Сангийн яамд хүргүүлж, FISCAL программд | 26 байгууллагын 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт оруулах саналыг хуулийн хугацаанд | 1.Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДТТХМ) болон төсвийн хязгаарт тусгах саналаа Сангийн яамнаас ирүүлсэн удирдамж, чиглэлийн дагуу хугацаанд боловсруулан хүргүүллээ. 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах ажлыг салбарын хэмжээнд төлөвлөн | 1-6 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | саналаа боловсруулж, харьяалагдах дээд шатны байгууллагад хүргүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулж хяналт тавих | | шивж оруулан, нэгтгэн боловсруулсан. | Сангийн яамд хүргүүлж, FISCAL программд шивж оруулан, эхний хагас жилийн мэдээ тайланг нэгтгэн боловсруулсан байна. | төсөл, арга хэмжээ, зардал бүрээр саналыг авч, ангилан харъяа 26 байгууллагаас саналыг авч нэгтгэн боловсруулж, Салбарын үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, үндэсний хэмжээнд байгаль орчны тогтвортой хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлэх, хүний нөөц, техник технологийн чадавхыг сайжруулах, хөрөнгө оруулалтын хэрэгцээг бодитоор тусган 2025 оны 05 дугаар сард 01/313 тоот албан бичгээр болон цахимаар хүргүүлсэн болно.<br>2. Боловсруулсан төсвийн саналд салбарын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай урсгал зардал, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийн төсөвт өртөг, хэрэгжүүлэх үндэслэл, үр өгөөж, хүрэх үр дүнг нарийвчлан тусгаж, шаардлагатай тоон болон чанарын мэдээллээр бүрэн хангаж боловсруулсан. Тус саналыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хугацаанд нь хүргүүлж, тус яамнаас Сангийн яаманд уламжлан, хамгаалан танилцуулах үйл ажиллагаанд хамтран оролцож, дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна. | | |
| 44 | Арга хэмжээ 6.6. Салбарын болон агентлагийн санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах, батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах, төсвийн зарцуулалтад хяналт тавих ажлыг | Салбарын болон байгууллагын батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулахад хяналт тавьсан явц | Харьяа байгууллага болон газрын 2024 онд хүрэлцэхгүй зардлыг тооцож, хэмнэгдэж байгаа зардлын төсвөөс зохицуулалт хийх саналыг Сангийн яаманд хүргүүлэн зохицуулж ажилласан. | 2025 оны 1-6 сард санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах, батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах, төсвийн зарцуулалтад | Газрын 2025 оны үндсэн болон туслах үйл ажиллагааны хувьд үндсэн тариф, үнэлгээгээр үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд нэмэгдсэн төсвийн зардлуудын тооцоог эхний хагас жилээр гарган ЦУОШГ-ын батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэх боломж, төсвийн тодотгол хийх санал боловсруулан ажиллаж байна. Салбарын хөрөнгө оруулалт болон урсгал зардлын төсвийн хуваарийг цаг тухай бүрд төсвийн шууд захирагч | 1-6 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж хяналт тавих | | | хяналт тавьсан байна. | нарын саналыг тусган, шилжүүлэг хийх хүсэлтийг хүргүүлсэн боловч хийгдэхгүйгээр өр төлбөр үүсэж байна. Гүйцэтгэлд хяналт тавьж, төсвийн дутагдалтай санхүүжилтийн тооцоог гарган ажиллаж байна. 2025 онд батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавиж ажилласан. | | |
| 45 | Арга хэмжээ 6.7. “Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулахад нэгдсэн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулалтад хяналт тавьсан байдал, үйл ажиллагааны хэрэгжилтийн явц | 2023 оны жилийн эцсийн тайлан, 2024 оны эхний хагас жилийн тайланг нэгтгэн гаргаж Сангийн яамны Э-тайланд шивж БОУАӨЯ-нд хүргүүлсэн. | 2024 оны жилийн эцсийн аудит хийгдсэн санхүүгийн тайланг нэгтгэн Сангийн яамны Э-тайланд шивж, БОУАӨЯ-нд хүргүүлнэ. | Газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлт хийсэн аудитаар илэрсэн зөрчил, акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөөг боловсруулан газрын даргын 2025 оны А/54 дугаар тушаалаар батлуулан 04 дүгээр сард 01/222 тоотоор Үндэсний аудитын газарт хүргүүллээ. Уг төлөвлөгөөг харъяа байгууллагуудад хүргүүлэн гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. | 1-6 | 70% |
| 46 | Арга хэмжээ 6.8. “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах, олон нийтэд мэдээллийг хүргэх” Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Мэдээ, мэдээллийг олон нийтэд тухай бүр хүргэсэн хуулийн хэрэгжилтийн хувь | 2023 оны IV-р улирал, 2024 оны сар, улирал, хагас жил, тухай бүр оруулах төсөв, худалдан авах ажиллагааны мэдээлэл, төсөв, тайланг хуулийн хугацаанд 100 хувиар байршуулсан. | 2024 оны 12 сар, IV-р улирал, 2025 оны 1 улирлын мэдээ, тайланг байгууллагын цахим хуудас, шилэн дансанд нийтлэх мэдээллүүдийг байршуулж, хэрэгжилтийг хангуулна. | 1. 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, төрийн худалдан авах байгууллагад хүргүүлсэн. Ханшийн зөрүү, хэрэгцээ шаардлагыг үндэслэн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан салбарын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэв. Тендер зохион байгуулах Үнэлгээний хороодыг байгуулан, хуулийн дагуу зохион байгуулж байна. Газрын урсгал төсвөөр хийгдэх худалдан авалтыг хүлээн авах ажлын хэсгийг батлуулсан.<br>2. Одоогоор 11 ажлын тендер зарлагдаж, 2 ажлын гэрээ байгуулан гүйцэтгэж, 6 шууд гэрээ байгуулагдан 3 ажлыг хүлээн аваад байна. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн | 1-6 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамт, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, санхүүгийн тайлангууд, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг тухай бүрд оруулсан, сард нэг удаа хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний болон тендерийн ерөнхий мэдээллийг шилэн дансны тухай хуулийн хугацаанд бүрэн байршуулж ажилласан. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн 1,2,3,4,5 дугаар сарын мэдээг сар бүрийн 8-ний дотор оруулж, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт мэдээг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор оруулж байна.<br>3. Тус салбарын зардал, орлого, хөрөнгө оруулалт, худалдан авалт болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нээлттэй байдлаар цахим хуудсаар дамжуулан нийтэлж, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байгаа болно. 2025 оны цэвэрлэгээний материал, бичиг хэргийн материал, шатахууныг жишиг нормын дагуу худалдан авалт хийсэн.<br>4. Няравын зарлагын бүртгэлийг улирлаар хянаж баталгаажуулан ажиллаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 47 | Арга хэмжээ 6.9. Холбогдох конвенцын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг хангаж ажиллах ажлыг зохион байгуулж хяналт тавих | ДЦУБ-аас зохион байгуулсан олон улсын хурал, сургалтад биеэр болон цахимаар хамрагдсан албан хаагчийн тоо | 120 албан хаагч сургалтад хамрагдсан. | 20-аас доошгүй албан хаагч сургалтад хамрагдана. | Газрын дарга томилогдсонтой холбоотойгоор ДЦУБ-ын Монгол дах суурин төлөөлөгчөөр томилогдов. Дэлхийн цаг уурын өдөр, Монголын Ус, Цаг уурын өдрийг тохиолдуулан байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх нэг сарын аяныг зохион байгуулан ажиллав. ДЦУБ-ын II-р бүсийн хурал 2025 оны 4 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд цахимаар зохион байгуулагдсан Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-ын II-р бүсийн хурлаар үндэсний болон бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллах боломж, нэн тэргүүнд анхаарах шаардлагатай асуудлуудын талаар санал, байр сууриа илэрхийлэн оролцлоо. RIMES сайд нарын хурал 2025 оны 5 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд БНАС Шри Ланка улсын нийслэл Коломбо хотноо зохион байгуулагдсан бөгөөд Монгол Улсын төлөөлөгчид тус хурлаар олон улсын сайн туршлагыг судалж, үндэсний хэмжээнд олон төрлийн гамшгаас урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулахад чиглэсэн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх санал дэвшүүлэн оролцсон болно. 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр ЦУОШГ нь Арабын Нэгдсэн Эмират Улсын (АНЭУ) хур тунадасны хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын мэргэжилтнүүдтэй цахим уулзалт зохион байгуулж Монгол орны байгаль, цаг уурын онцлогт тохирсон технологи | | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нутагшуулах боломж, чиглэлүүдийг хэлэлцэв. ЦУОШГ, БНСУ-ын Цаг уурын газар хооронд Цаг уурын салбарт хамтран ажиллах хоёр талт 11 дүгээр уулзалт 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр БНСУ-ын Сөүл хотноо амжилттай зохион байгуулагдсан. ЦУОШГ нь Хааны бороо хөдөө аж ахуйн агаарын тээврийн газартай “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хөгжүүлэх” хамтын ажиллагааны хүрээнд 6 дугаар сарын 27-ны өдөр ЦУОШГ-т зочилж хамтын ажиллагааны санамж бичгийг сунгаж гарын үсэг зурах үйл ажиллагааг хийнэ. Метео франс интернэйшнл компанийн төлөөлөгчид Монгол Улсын Цаг уурын байгууллагуудтай хамтран ажиллах, шинэ төсөл хэрэгжүүлэх боломжийг судлах уулзалтыг зохион байгуулсан. Олон улсын болон хамтын ажиллагааны хүрээнд салбараас сургалт, семинар, олон улсын хуралд 22 албан хаагч хамрагдсан байна. Орчны шинжилгээний автомат багажаар хангах БНСУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд энэ жил 21 аймагт суурлуулах ажлыг Архангай аймгаас эхлүүлээд 10 гаруй аймгийн багаж тоног төхөөрөмжийг хүлээн аваад байна. Гадаад худалдан авалтын 3 гэрээг хийж 1 ажлыг бүрэн гүйцэтгэж хүлээн авлаа. Хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын Цаг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уурын албатай Цаг уурын шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах хамтарсан ажлын хэсгийн 17 дугаар протоколын хугацаа энэ жил дуусаж байгаа тул хамтран дүгнэж, 18 дугаар уулзалтыг Монголд зохион байгуулахаар ажиллаж байна. Цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэхээр Швед, Финланд, Хааны бороо, Франц, ОХУ, Турк, Япон зэрэг улсуудтай, Жайка, Койка, Тика зэрэг Олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд хамтран ажиллах боломжийг судлан ажиллаж байна. | | |
| 48 | Гүйцэтгэлийн зорилт 7: Салбарын албан хаагчдын эрхийг хамгаалах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, сургалт, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Ажлын давхардал арилгах чиг үүргийн шинжилгээ хийсэн эсэх<br><br>Шинэчлэн батлуулсан эсэх | 2020-2024 оны нийгмийн баталгааг хангах, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт бүрэн биелүүлсэн. | -2025-2028 оны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр,<br>-2025 он сургалтын төлөвлөгөөг батлуулсан байна. | Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулан 2025 оны 06 дугаар сарын 12-ны А/114 тоот албан тушаалаар батлагдсан байна. | 1-6 | 100% |
| 49 | Арга хэмжээ 7.1. Төрийн албаны тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стандартын хэрэгжилтийг хангаж, харьяа 25 байгууллага, газрын нэгжийн болон | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг тогтоол, журмын дагуу батлуулж, биелэлтийг тайлагнасан явц | 2024 онд 25 байгууллага, 6 хэлтэс, 68 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, хяналт, үнэлэлт өгч урамшуулал олгосон. | 2025 оны 25 байгууллага, 6 хэлтэс, 68 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хагас жилийн үнэлгээ хийлгэнэ. | Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагуудын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн тайлан хүлээн авсан. Харьяа байгууллагуудын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлсэн байна. | 1-6 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнах, урамшуулах ажлыг зохион байгуулж хяналт тавих | | | | | | |
| 50 | Арга хэмжээ 7.2. Газар, харьяа байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн болон цаг уурын ажиглалтын технологийн дотоод хяналт шалгалт хийж зөвлөмж гаргах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Хяналт шалгалт хийсэн эсэх | 2023, 2024 оны үйл ажиллагаанд санхүү шалгалт хийсэн. Цаг уурын технологи, заавар мөрдүүлэх, үл тохиролд хяналт тавьж ажилласан. Шалгалт хийгдсэн 5 байгууллагад зөвлөмж хүргүүлсэн. | 2024 оны санхүү үйл ажиллагаанд шалгалт хийнэ. Цаг уурын хэмжлийн технологи, заавар мөрдүүлэх, үл тохиролд хяналт тавьж ажиллана. Шалгалт хийгдсэн байгууллагуудад зөвлөмж хүргүүлнэ. | Цаг уурын ажиглалтыг нийт 138 өртөө, 181 харуулд тухайн хуваарьт цаг бүрд хийж байна. Үүнд тогтмол хяналт тавьж ажиллахад зарим элемент хэмжлийн тасалдал үүсэж байна. Энэ байдал нь автомат станцын ажиллагаа болон сүлжээний доголдол, тог тасралт, хувь хүний хариуцлага, цаг агаарын аюулт үзэгдэл зэргээс шалтгаалсан. Эхний хагас жилд цаг уурын өртөөнөөс нийт 47 салбарт далайн түвшний даралтын утга сүлжээнд 197 удаа байхгүй, 2 өртөөнд сараас дээш хугацаагаар доголдол гарч нэг нь засагдсан. Багануур өртөөнд шалгалт хийгдсэн, ажиллах нөхцөл сайжруулсан байна. Тухай бүр зөвлөгөө өгч ажиллаа. “Шилэн дансны тухай” хуулийн дагуу мэдээллийг ангилал тус бүрээр байгууллагын цахим хуудас болон www.shilendans.gov.mn сайтад байршуулан иргэд, олон нийтэд мэдээллээ ил тод, хуулийн хугацаанд байршуулсан эсэхийг хяналт тавин ажилласан. 2024 оны жилийн эцсийн болон 2025 оны 1, 2-р улирлуудын шилэн дансны танилцуулга, хэрэгжилтийг гаргаж БОУАӨЯ-нд албан тоотоор хүргүүлсэн байна. | 1-6 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 51 | Арга хэмжээ 7.3. Байгууллагын архив, бичиг баримтыг холбогдох хууль, тогтоомж, стандарт, заавар журмын дагуу эрхлэн явуулах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Мөрдөж ажилласан заавар, журмын тоо | 2023, 2024 оны жилийн тайлан гаргасан, баримт бичгийг хууль, журмын дагуу эмх цэгцтэй хадгалж ажилласан. | 2024 оны баримт бичгийг хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэн санд байршуулах,баримтаар үйлчлэх, дүн тоо мэдээг нэгтгэн гаргана. | Байгууллагын архивд 109 баримтыг стандартын дагуу үдэж хавтаслан эмхлэн цэгцэлж бүртгэл үйлдэн, зааг тавиурт байршуулан ажиллаж байна. Хагас жилийн байдлаар иргэд, харьяа байгууллагад 29 албан бичгээр, 16-н албан хаагч, мэргэжилтнүүдэд нийт 279 баримтаар үйлчилж ажиллаа.<br>Хадгаламжийн санд стандартын дагуу өрөөний чийг дулааныг нийт 28 удаагийн хэмжилт хийж, 29 удаагын цэвэрлэгээ 2 удаагийн ариутгалыг хийж ажилласан. | 1-6 | 100% |
| 52 | Арга хэмжээ 7.4. Байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх ажлыг зохион байгуулж хяналт тавих | Контентын тоо | 1 | 1 | Авлигын эсрэг ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 1 видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байна. | 1-6 | 100% |
| 53 | Арга хэмжээ 7.5. Цаг агаарын 10 хоногийн урьдчилсан төлөвийг сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан дохионы хэлмэрчтэй видео мэдээлэл хийх, түгээх ажлыг | 1.Видео мэдээллийн тоо<br>2. Хандалтын тоо | - | 25 ба түүнээс дээш тооны видео мэдээлэл хийх >5 мянгаас их байх | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж 10 хоногийн мэдээг дохионы хэлтэй болгох гэрээ байгуулахад санхүүгийн боломжгүй гэсэн тул ажил хэрэгжээгүй. Гэрээний төсөл, хамтран ажиллах хэлэлцээрийн түвшинд явагдаж байна. | 1-6 | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж хяналт тавих | | | | | | |
| 54 | Арга хэмжээ 7.6. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлыг зохион байгуулж хяналт тавих | ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан эсэх | Ажлын хэсэг байгуулсан. | Хуулийн үзэл баримтлалыг батлуулах, салбарын саналыг нэгтгэн боловсруулж БОУАӨЯ-нд хүргүүлнэ. | Хуулийн төслийг боловсруулах, төслийн багийг сонгон шалгаруулах 2 ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Хуулийн төсөлд салбарын албан хаагчдаас санал авч ирсэн 185 саналуудыг нэгтгээд Яамны ажлын хэсэгт 2 удаа, газрын даргын зөвлөлд 2 удаа хуулийн танилцуулга, өөрчлөх үндэслэл, хэрэгцээ, шаардлага, ямар өөрчлөлт хийх зэрэг мэдээлэл хийсэн. ХТТХ-ийн дагуу УЦУОШТХ-ийг шинэчилсэн найруулга хийсэн хуулийн төслийг боловсруулах, өргөн барихад бэлтгэх, “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдлийн менежментийг боловсронгуй болгох нь” /АДАПТ/ төсөлд хуулийн төслийг ХТТХ-ын шаардлага хангуулах 5 зөвлөх үйлчилгээний ажлыг санхүүжүүлэх саналыг тавьж шийдвэрлүүлсэн, . “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, шинэчилсэн найруулга хийх хуулийн хэрэгцээ шаардлагыг тандан судлах, хэлэлцүүлэг зохион байгуулах”, “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлуулах”, 2 багц зөвлөх багийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулан, хэлэлцүүлэг зохион | 1-6 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулах” ажлын даалгаврыг батлуулан сонгон шалгаруулалтыг хийж байна. Өөрийн байгууллагын сайт дээр “УЦУОХШТХ”-ийг шинэчлэх ажлын талаар хийгдэж байгаа ажлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг эхлүүлсэн. Ажлын хэсэг, зөвлөх багийн хэлэлцүүлгүүдийг хийж байна. Ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. | | |
| ДӨРӨВ. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт<br>“Хүн төвт хөгжлийн хөтөлбөр”-үйл ажиллагааны чиглэл 2.3. Ус цаг уур, орчны шинжилгээний болон байгаль орчны мэдээллийн санг шинэ технологи, хайлтын систем бүхий ашиглахад хялбар цогц цахим систем бий болгох | | | | | | | |
| 55 | Гүйцэтгэлийн зорилт 8: Төвийн бүсийн мезомасштабын ус, цаг уурын үзэгдлийн хэт богино хугацааны прогнозын систем боловсруулах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Хэрэгжилтийн явц | - | Системийг боловсруулж нэвтрүүлсэн байх | Хэт богино хугацааны загварын оролтын мэдээгээр анхны нөхцөлийг ассимляци хийх хиймэл дагуулын босоо профиль, радар болон газрын мэдээ бэлтгэсэн. | 1-6 | 30% |
| 56 | Арга хэмжээ 8.1. Шинэ өндөр хүчин чадалтай тооцоолох төхөөрөмж, суперкомпьютерыг суурилуулах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Суперкомпьютер худалдан авах, суурилуулах ажлын явц | Шинэ суперкомпьютер худалдан авах тендерийг НҮБ-ээс зарлаж, худалдан авах ажиллагаа явагдаж байна. | Суперкомпьютерын өрөөний хөргөлтийн систем, тог баригчийн суурилуулж бэлтгэл ажлыг хангасан байна. | Суперкомпьютерын өрөөний агааржуулагчийн болон хөргөлтийн систем суурилагдан хэвийн ажиллуулж эхэлсэн. Мөн тог баригчийн систем суурилагдаж тест хийн ажиллуулсан.<br>2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр шинэ суперкомпьютерыг асааж цахилгааны ачааллын тест хийж ажиллуулах боломжтой гэж дүгнэсэн. Шинэ системийн сүлжээний холболт хийгдэж эхэлсэн. | 1-6 | 90% |
| 58 | Арга хэмжээ 8.3. WRF-Hydro загварыг зүгшрүүлж, турших ажлыг зохион | Туршилтын тоо | - | Туул голын сав газрын усны харуулууд дээр загварыг | - Туул голын сав газрын харуулуудаар мэдээлэл бүрдүүлэлт хийгдсэн. Туул голын үертэй үе болох 2024 оны 6 дугаар сарын 19-25-ны өдрүүдэд суурь | 1-6 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулж хяналт тавих | | | ажиллуулсан байна. | мэдээ, бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэв.<br>- Эхний ээлжид өндөр хүчин чадалтай (workstation) компьютерт хамгийн хурдан бодогдох процессорын хэмжээг олох туршилтаас гадна WRF-GPU суулгах оролдлого хийсэн.<br>- WRF загварын хамгийн хурдан процессорын тоогоор туршилтын бодолтыг өгсөн ба үүний зэрэгцээ ижил хугацаагаар NWP-SERVER компьютерт мөн бодолтыг бодуулж байна. Суперкомпьютэр суурилагдахаар загварын туршилтын бодолт үргэлжлэн хийгдэнэ. | | |
| 59 | Арга хэмжээ 8.4. Цаг агаарын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээний арга, технологи боловсруулах, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих | Арга технологи нэвтрүүлсэн эсэх | - | Хүчтэй салхи, цасан болон шороон шуурганы нөлөөллийн прогнозын арга технологи боловсруулах, нэвтрүүлэх. Нийгэм эдийн засгийн суурь мэдээллийн сан бүрдүүлнэ. | 1.Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, ган, зудын нөлөөллийн прогнозын аргазүйг нарийвчлан боловсруулахад шаардлагатай ажлыг тодорхойлов. Дараах хугацаанд нөлөөллийн прогнозыг гаргав.<br>2. 2024 оны 11 дүгээр сарын 30, 2024 оны 12 дугаар сарын 31, 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрүүдэд зудын эрсдэлийн зурагт үндэслэн Зудын нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөв"-ийг боловсруулав. Зудын үед хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагааны процедурыг гаргаж нэмэлт санал, өөрчлөлтийг холбогдох хүмүүсээс авсан.2024 оны 06 дугаар сарын 30-ны туршилтаар гаргасан гангийн эрсдэлийн зурагт үндэслэн Гангийн нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөвийг туршилтаар боловсруулав.<br>3. 2024 оны 02 дугаар сарын 16-ны хүчтэй салхи, шуурганы загварын | 1-6 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээнд тулгуурлан хүчтэй салхины нөлөөллийн урьдчилсан мэдээг боловсруулав.<br>4. https://weather.gov.mn/ болон “Ус цаг агаар, орчны мэдээ мэдээлэл” нэртэй цахим хуудсанд шинэ бүтээгдэхүүний тайлбар, танилцуулга, богино бичлэгийг олон нийтэд хүргэсэн.<br>5. Нэгдсэн мэдээллийн санг нөлөөллийн урьдчилсан мэдээний оролт болон гаралтын мэдээнүүдээр үүсгэсэн бөгөөд SQL-Мэдээллийн бааз, газарзүйн мэдээллийн системд суурилсан Shape өргөтгөлтэй мэдээллийн сангаас бүрдэнэ. Нийгэм-эдийн засгийн суурь мэдээг орон нутгийн болон улсын хэмжээнд Үндэсний статистикийн хороо, Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн ерөнхий газар болон бусад холбогдох байгууллагуудаас цуглуулж, хяналт шалгалт хийж энэхүү санг баяжуулсан. Нэмэлтээр орон нутгийн түвшинд мэдээ оруулах хэрэглэгч хандалтын дэд программыг хөгжүүлсэн.<br>6.Нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээг хэрэглэгчдэд хүргэх веб суурьтай платформ хөгжүүлсэн бөгөөд үүнд хүчтэй салхи, цасан шуурга, ган, зуд зэрэг цаг агаар, уур амьсгалын гамшигт үзэгдлүүдийн урьдчилсан мэдээ багтана. Тухайн урьдчилсан мэдээг томруулж, жижгэрүүлж харах, өндөр даваа гүвээний байрлалыг тодорхойлох, өртөх байдлын зэрэглэлийн өнгөөр нь ялган харах, үргэлжлэх хугацаагаар нь гүйлгэж харах, мөн үргэлжлэх хугацааны хамгийн их утгаар нь харах боломжтойгоор хийгдсэн. Мөн засаг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | захиргааны хилээр хуваагдсан багийн түвшинд нийгэм эдийн засгийн мэдээллийг харах, анхааруулах зурган мессежийг давхар авах боломж бүрдсэн. | | |
| 60 | Арга хэмжээ 8.5. Монгол орны байгаль, нийгэм, эдийн засагт хамгийн их нөлөө үзүүлж буй уур амьсгалын 11 экстремал индексийг үр дүнг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж хяналт тавих | цувааны урт/ индексийн тоо | 1961-2023 оны мэдээгээр 11 экстремал индексийг тооцоолж, үр дүнг цахим сайтад байршуулсан. | 2024 оны мэдээгээр цуваag уртасгаж, уур амьсгалын 11 экстремал индексийг тооцоолж, үр дүнг цахим сайтад байрлуулна. | 56 өртөөний 1961-2023 оны экстремаль индекс тооцоолдог хоногийн цувааг 2024 оноор уртасгаж, уур амьсгалын 11 экстремаль индексийг тооцоолж, үр дүнг www.http://climate-service.mn/climateservice/ болон www.irimhe.namem.gov.mn цахим хуудаснуудад байршуулж олон нийтэд хүргэсэн. | 1-6 | 100% |
| 61 | Арга хэмжээ 8.6. Агаарын дундаж температур, хур тунадасны 10 хоногийн стандарт нормыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Цувааны урт, өртөө/харуулын тоо | 1991-2020 оны сар, жилийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны нормыг 137 өртөө, 181 харуулаар тооцоолсон. | 1991-2020 оны мэдээгээр 10 хоногийн агаарын дундаж температур, хур тунадасны нормыг 138 өртөө, 180 харуулаар тооцоолсон байна. | Цаг уурын 181 харуулын 1991-2020 оны агаарын температур, хур тунадасны цувааг нэгэн төрлийн болгон, 10 хоногийн нормыг боловсруулсан. Гарсан үр дүнг шалгаж байна | 1-6 | 100% |
| 62 | Арга хэмжээ 8.7. Шуурхай үйлчилгээний динамик загваруудыг сайжруулах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Прогнозны урьдчилал | Прогнозын урьдчиллыг хугацаа 144 цаг байдаг. | Суперкомпьютер ашиглан цаг агаарын аюултай үзэгдлийн тохиолдолд бүсийн түвшинд 1-5 км нарийвчлалтай бодуулах шуурхай | Шинэ суперкомпьютерын технологийг ашиглан WRF-UM загварын прогнозын урьдчиллыг 240 цаг болгон нэмэгдүүлэхэд шаардлагатай бэлтгэл ажил хуучин суперкомпьютер дээр хийгдсэн. 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Суперкомпьютерыг асааж цахилгааны тестийг хийсэн. | 1-6 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагааны горимыг тогтооно. | | | |
| 63 | Арга хэмжээ 8.8. Гангийн мониторингийн системийг шинэчлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих | Мониторингийн систем | 2020 оны Гангийн систем ашигладаг. | Ганг илэрхийлэх индексүүдийг тооцоолох, ажиглалтын мэдээг бэлтгэн боловсруулна. | Зайнаас тандан судлалын хэлтсийнхэнтэй хамтарч хиймэл дагуулын мэдээ ашиглан ганг илэрхийлэх индексүүдийг тооцоолох, газрын ажиглалтын мэдээтэй харьцуулж үнэлэх, гангийн зураглал боловсруулах арга технологи бий болгохоор ажлыг гүйцэтгэж байна. | 1-6 | 30% |
| 64 | Арга хэмжээ 8.9. Мөнх цас, мөсний массын гулсалтыг тодорхойлох ажлыг зохион байгуулж хяналт тавих | Шилжилтийн хурд, метр/хоног | - | Түргэн, Ботанин, Цамбагаравын мөсөн голын хээрийн хэмжилт судалгааны ажлыг эхлүүлсэн байна. | Энэ ажлын хүрээнд мөсөн голын мөсний гадаргын байршлын зураглалыг Түргэн, Ботанин, Цамбагарав гэсэн нэгжээр хийсэн. | 1-6 | 70% |
| 65 | Арга хэмжээ 8.10. ДЦУБ-гаас Цаг уурын ажиглалтын мэдээлэл солилцооны WIS2.0 системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих | Хэрэгжилтийн явц | WIS2.0 системийг нэвтрүүлэхээр БНХАУ-ын Цаг уурын бүсийн төв /CMA/-тай хэлэлцүүлэг хийж, туршлага судалсан. | Сервер компьютер худалдан авч, систем, программыг суулгана. | JMA нь 2025 оны 2 дугаар сарын 26-нд WIS портал GISC-Tokyo холболтыг шинэ системд шилжүүлсэн бөгөөд манай төв MSS серверүүд дээрх GISC-Tokyo холболтын хаягийн өөрчлөлт тохиргоо хийн шинэ систем дээр мэдээ солилцох боломжийг бүрдүүлэн ажилласан.<br>Сервер компьютер худалдан авах захиалга өгсөн, худалдан авах ажиллагаа хийгдэж байгаа тул систем, программыг суулгах ажил хийгдээгүй байна. | 1-6 | 70% |
| 66 | Арга хэмжээ 8.11. Мэдээлэл солилцоо, дамжуулалтын чанарыг сайжруулах, дотоод сүлжээний тоног | Хэрэгжилтийн явц | Цаг уурын нэгдсэн сүлжээний роутерийн тохиргоог хийж, сүлжээнд тавихад бэлдсэн. | Цаг уурын нэгдсэн сүлжээний цөм роутерийн тохиргоо хийгдсэн байна. | Цаг уурын нэгдсэн сүлжээний роутерийн тохиргоог хийж, сүлжээнд тавихад бэлдсэн.<br>Шинэ суперкомпьютер суурилуулж, алсын зайнаас хандаж систем програм хангамж суулгах ажлын хүрээнд | 1-6 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төхөөрөмжийг шинэчлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих | | | | шинэ роутерийг сүлжээнд тавьж бэлдсэн. | | |
| 67 | Арга хэмжээ 8.12. Ус, цаг уур, орчны өртөө, харуулын мета өгөгдлийн сан байгуулах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Байгуулсан өгөгдлийн сангийн ажлын явц, гүйцэтгэл, хувь | 0 | 25 | Мета өгөгдлийн сан байгуулах тандан судалгааны хүрээнд ДЦУБ болон бусад байгууллагын /статистикийн газар, онцгой байдал, opendata.mn/ мэдээллийн сангийн бүтэц, агуулгийг судаллаа. ДЦУБ-ын OSCAR/Surface платформ болон зөвлөмжөөс жишиг болгон суурь түвшний жагсаалт гаргаж байна. | 1-6 | 70% |
| 68 | Арга хэмжээ 8.13. MNS ISO IEC 17025:2018 стандартын дагуу хэмжил зүйн лабораторийн итгэмжлэлд хамрагдах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Итгэмжлэлд хамрагдсан лабораторийн хэрэгжилтийн хувь | 0 | 1 | Хэмжилзүйн лабораториос MNS ISO IEC 17025:2018 стандартын шаардлагын дагуу холбогдох материалыг бүрдүүлэн Итгэмжлэлийн үндэсний төвд хүргүүлсэн бөгөөд урьдчилсан баримт бичгийн шалгалтыг тус хорооноос хийж байна. | 1-6 | 70% |
| 69 | Арга хэмжээ 8.14. MNS ISO IEC 17025:2018 стандартын дагуу орон нутгийн БОШЛ-уудыг итгэмжлэлд хамруулах, итгэмжлэл сунгуулах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Итгэмжлэл сунгасан лабораторийн тоо | 16 | 17 | Итгэмжлэлийн Үндэсний төвөөс нэгдсэн журмаар итгэмжлэлд хамруулах бодлого барьж байгаа учраас төвөөс стандартын шаардлага хангасан эсэхэд аудит болон хяналт хийх шаардлагатай байна. | 1-6 | 50% |
| 70 | Арга хэмжээ 8.15. MNS4585:2016 стандартыг шинэчлэн боловсруулж батлуулан | Шинэчлэн боловсруулсан стандартын тоо | 1 | MNS4585:2016 стандартыг шинэчлэн боловсруулсан байна. | БОУАӨСайдын 2025.01.10-ны А/03 тушаалаар батлагдсан MNS4585:2016 стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ЦУОШГ болон БОХЗТЛ-ын 5-н албан хаагч ажиллаж шинэчлэх ажлыг гүйцэтгэсэн. Стандарт | 1-6 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих | | | | хэмжилзүйн ерөнхий газрын даргын тушаал гарч хэрэглээнд нэвтэрнэ. | | |
| 71 | Арга хэмжээ 8.16. Уур амьсгал тойм болон орчны төлөв байдлын жилийн эмхэтгэл боловсруулж, хэвлүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих | Эмхэтгэлийн тоо | - | Ус, уур амьсгал, хөдөө аж ахуй, орчны төлөв байдлын талаарх мэдээллийг нэгтгэсэн жилийн тоймын ерөнхий агуулгыг гаргаж, батлуулсан байна. | Цаг уурын нэгдсэн сүлжээний роутерийн тохиргоог хийж, сүлжээнд тавихад бэлдсэн.<br>Шинэ суперкомпьютер суурилуулж, алсын зайнаас хандаж систем программ хангамж суулгах ажлын хүрээнд шинэ роутерийг сүлжээнд тавьж бэлдсэн. | 1-6 | 70% |
| 72 | Арга хэмжээ 8.17. Газрын үйл ажиллагаанд ISO9001 чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Газрын үйл ажиллагаанд ISO9001 стандартыг нэвтрүүлсэн хэрэгжилтийн хувь | - | Газрын үйл ажиллагаанд ISO9001 стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | 1. СТХАХ-ын үндсэн болон туслах үйл ажиллагааны процесс зураглалыг хийсэн. Санхүү болон газрын дотоод асуудалтай холбоотой дотоод журам боловсруулах ажлыг хийсэн.<br>2. 2025 онд Цаг уур, орчны шинжилгээний газар нь Чанарын Менежментийн Тогтолцооны бодлогоо тасралтгүй сайжруулж хэрэглэгчдийн хүсэл, шаардлагад нийцсэн чанартай, найдвартай, түргэн шуурхай мэдээлэл үйлчилгээ үзүүлэгч "ISO9001-2015" тогтолцоог нэвтрүүлсэн байгууллага болох зорилт тавин ажиллаж байна.<br>3. Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны А/20 дугаар тушаалаар шинэчлэн томилогдсон ажлын хэсэг нь ОУ-ын Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг Газрын даргын тушаалаар батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу ажлын байрны тодорхойлолт заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. | 1-6 | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. “Цаг уур орчны шинжилгээний газар”-ын үйл ажиллагаанд ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцооны стандартын шаардлагуудад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээний “ЭКО НЭЙШНЭЛ” ХХК-тай хамтран зөрүүгийн шинжилгээг хийж гүйцэтгэлээ.<br>5. Зөрүүгийн шинжилгээний ажлын хүрээнд “Цаг уур орчны шинжилгээний газар”-ын бүх үйл ажиллагаанд нийт 57 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 25 үзүүлэлт биелсэн, 16 үзүүлэлт бүрэн бус биелэлтэй, 16 үзүүлэлт биелээгүй буюу 48.4% хэрэгжилттэй байна. Цаг уур орчны шинжилгээний газарт эдгээрээс 14 баримт бичгийн төрөл байна, 15 төрлийн баримтжуулсан мэдээлэл болон баримт бичиг байхгүй мөн байгаа боловч сайжруулах шаардлагатай байна.<br>6. Хууль эрх зүйн болон бусад шаардлагуудыг тодорхойлох, нийцлийг үнэлэх жишиг журмын дагуу үнэлэх ажлыг хийж байна. үнэлгээний эцсийн үр дүн гараагүй байна. Салбарын хэмжээнд дагаж мөрддөг 45 хууль эрх зүйн акт байна. салбарын хэмжээнд дагаж мөрддөг заавар, журам, стандартын нийцлийг мөн хийж байна. Мөн байгууллагын төлөв байдлыг тодорхойлох ажлыг хийв. Баримт бичгийн бүртгэл жагсаалт гаргав. Байгууллагын үйл ажиллагааны процессын зураглалыг Газрын хэмжээнд болон хэлтэс, нэгж бүрээр хийсэн. Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний бүтэц, агуулга | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулав. Мандатын шинжилгээ хийв.<br>7. Сургалт, идэвхжүүлэлт: 2025 онд Цаг уур, орчны шинжилгээний газар үйл ажиллагаандаа "Чанарын менежментийн тогтолцооны ISO9001-2015" стандартыг нэвтрүүлэх зорилт тавин "Эконэйшнл" ХХК-аас зөвлөх үйлчилгээ аван хамтран ажиллаж байна.<br>8. 2025 онд ЦУОШГ нь Чанарын Менежментийн Тогтолцооны бодлогоо тасралтгүй сайжруулж хэрэглэгчдийн хүсэл, шаардлагад нийцсэн чанартай, найдвартай, түргэн шуурхай мэдээлэл үйлчилгээ үзүүлэгч "ISO9001-2015" тогтолцоог нэвтрүүлсэн байгууллага болох зорилт тавин ажиллаж байна.<br>Тайлангийн хугацаанд нийт 9 удаагийн сургалт авав. Үүнд:<br>- Зөрүүгийн шинжилгээ -Чанарын удирдлагын тогтолцооны стандарт<br>- Байгууллагын төлөв байдлыг тодорхойлох<br>- Баримтжуулсан мэдээлэл<br>- Бодлого, зорилго, зорилт тодорхойлох<br>- Процесс зураглал<br>- Хууль тогтоомж болон бусад шаардлагыг тодорхойлох, нийцтэй байдлын үнэлгээ хийх<br>- Үйл ажиллагааны эрсдэл боломжийг тодорхойлох<br>- Байгууллагын мэдлэг, өөрчлөлтийн удирдлага.<br>ЦУОШГ-ын даргын 2025 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А/65 тоот тушаалаар 12 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй аудитын баг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулагдсан ба тус дотоод аудит хийх ажилд 10 албан хаагч оролцсон. “Чанарын менежментийн тотолцооны дотоод аудитын төлөвлөгөө”-ний дагуу дотоод аудитын ажлыг 2025 оны 05 дугаар сарын 07-нд ЦУОШГ-т хийв. ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтийг нийт 63 үзүүлэлтээр үнэлгээ хийхэд 40 тохирол түүнээс 15 сайжруулах боломж байсан. Түүнчлэн 23 үл тохирол илэрсэн. Залруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. | | |
| 73 | Арга хэмжээ 8.18. Цаг уурын суурин радарын мэдээллийг нэгтгэн боловсруулж харуулах мэдээллийн систем байгуулах ажлыг зохион байгуулж хяналт тавих | Мэдээллийн системийг үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн байх, хувь | 0 | 100% | Цаг уурын суурин радарын мэдээллийг нэгтгэн боловсруулж харуулах мэдээллийн систем бий болсон. Урьдчилан мэдээлэх өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн. | 1-6 | 100% |
| 74 | Арга хэмжээ 8.19. Монгол Улс болон БНХАУ-ын нисэхийн цаг уурын үйлчилгээг сайжруулах, SIGMET хамтын ажиллагааг эхлүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих | Мэдээний чанар сайжирсан эсэх | - | SIGMET мэдээлэл хоорондын зөрүүтэй байдлыг багасгана. | Монгол улс нь БНХАУ-тай 6 агаарын хаалгаар Урумчи, Ланжау, Бээжин, Шеньян гэсэн 4 нислэгийн мэдээллийн бүсийн хилээр холбогддог. НЦУТ нь 2025 оны 1 сарын 15-аас эхлэн нислэгт аюултай цаг агаарын үзэгдлийн SIGMET мэдээний агуулга, үйлчлэх хугацаа, газарзүйн байршил ба өндөр, эрчимжил, хугацаа, шилжилтийн талаар хэлэлцүүлгийг УБ-ын цагаар өдөр бүр 10 цаг 30 минутаас тогтмол хийж байна. | 1-6 | 100% |
| 75 | Арга хэмжээ 8.20. Гар утасны аппликейшн шинэчлэх ажлыг | Хэрэгжилтийн явц, | 70 | Гар утасны аппликейшнийг бүрэн | Гар утасны аппликейшн хөгжүүлэх үйл явц, технологийн сонголтууд, хөгжүүлэлтийн шат дамжлага, зардлын тооцоо, болон зах зээл дээрх ижил | 1-6 | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж хяналт тавих | | | ажиллагаанд оруулсан байх | төстэй аппуудын жишээг судалж байна. | | |
| Дундаж биелэлт | | | | | | | 89.1 |

### Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | ISO9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны стандарт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих | Стандарт хэрэгжиж эхэлсэн эсэх | - | Сургалт хөтөлбөрт хамрагдаж ажиллана. | Цаг уур,орчны шинжилгээний газрын харьяа Нислэгийн цаг уурын төв ISO9001:2015 олон улсын чанарын удирдлагын стандартыг амжилттай нэвтрүүлж, батламжийг 2025 оны 06-р сарын 09-ны өдөр гардан авсан. | 1-6 | 100% |
| 2 | Мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл хамтран бичиж нийтлүүлэх | Нийтлүүлсэн өгүүллийн тоо | - | 1 | Мэргэжлийн чиглэлээр “Climate change impact of land cover changes in the Kharkhiraa-Turgen mountain region” эрдэм шинжилгээний өгүүллийг доктор Ц.Сэр-од нарын хамт “Mongolian Geoscientist” сэтгүүлд нийтлүүлсэн. | 1-6 | 100% |
| 3 | Цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр олон улсын хурал, зөвлөгөөнд оролцох | Оролцсон бага хурал, зөвлөгөөний тоо | - | 1 | БНСУ-ын Сөүл хотноо болсон Цаг уурын салбарын хамтын ажиллагааны БНСУ, Монгол Улсын 11 дүгээр протоколын уулзалтад оролцож, шар шороон шуурганы мониторингийг сайжруулах, ADAM3 загварын шинэчлэл, хөгжүүлэлтийг үргэлжлүүлэх, цаг агаарын урт хугацааны прогнозын нарийвчлал, чанарыг нэмэгдүүлэх, цаг уурын мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх, сургалт, | 1-6 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дадлагажуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр тохиролцсон. Шри Ланка улсын Коломбо хотод болсон Ази-Африкийн бүсийн олон төрлийн гамшгаас эртнээс сэрэмжлүүлэх нэгдсэн систем (RIMES)-ийн 4 дүгээр чуулганд оролцсон. Энэхүү чуулганд 45 орны Засгийн газрын төлөөлөгчид оролцож, RIMES-ийн Мастер төлөвлөгөөг баталсан юм. БОУАӨ-ийн сайд С.Одонтуяагийн илтгээлт, Монгол Улсаас байгалийн гамшгийн эрт сэрэмжлүүлгийг сайжруулах чиглэлээр хийж буй ажлуудаа танилцуулав. | | |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:

| | |
|---|---|
| АМСХ | Архив, мэдээллийн сангийн хэлтэс |
| БОУАӨЯ | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам |
| БОХЗТЛ | Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори |
| ДЦУБ | Дэлхийн цаг уурын байгууллага |
| ЗАХ | Захиргаа, аудитын хэлтэс |
| НЦУТ | Нислэгийн цаг уурын төв |
| ОБЕГ | Онцгой байдлын ерөнхий газар |
| ОШХ | Орчны шинжилгээний хэлтэс |
| УМХ | Урьдчилан мэдээллэх хэлтэс |
| УСУАҮХ | Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтэс |
| УЦУОСМХ | Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн |
| УЦУОШТ | Ус цаг уур орчны шинжилгээний төв |
| ЦАЗН | Цаг агаарт зориудаар нөлөөлөх |
| ЦУОШГ | Цаг уур, орчны шинжилгээний газар |

----оОо----